



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (583)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай*
- *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Ноот бичиг соёрхон батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвтэл

Улаанбаатар хот

2009 оны гуравдугаар сарын 12

№10 (583)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

171.	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (шинэчилсэн найруулга)	145
172.	Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	153
173.	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	154
74.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	154
75.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	155
76.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	155
77.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	155
78.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	156
79.	Ноот бичиг соёрхон батлах тухай	156

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

30.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 21	156
-----	----------------------------	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

39 оны 02 дугаар
эрин 13-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, ний удирдлага, зохион байгуулалтыг зорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол мшүүлэх, мэргэжлийн ур чадвар олгох, шлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн

2 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж

2.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Боловсролын тухай², Бага, дунд



боловсролын тухай³, Дээд боловсролын тухай⁴, Хөдөлмөрийн тухай⁵, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай⁶, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хууль нь өмчийн аль ч хэлбэрт түшиглэн мэргэжлийн боловсрол, сургалтыг зохион байгуулах хуулийн этгээдэд хамаарна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "мэргэжил" гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.1.2. "мэргэжлийн боловсрол" гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшилийг;

4.1.3. "техникийн боловсрол" гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшилийг;

4.1.4. "мэргэжлийн сургалт" гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагааг;

4.1.5. "мэргэшил" гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг;

4.1.6. "мэргэжлийн суурь чадвар" гэж нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшилийг;

4.1.7. "мэргэжлийн үндсэн чадвар" гэж аливаа ажил үүрэг бие даан гүйцэтгэх, ажиллыг өөрчлөлтөд зохицон өсөж хөгжих чадварыг;

4.1.8. "модуль" гэж тодорхой ажиг мэргэжлийн чадамж эзэмшүүлэхэд чиглэс харилцан уялдаа бүхий сургалтын нэгж ажилбарыг

4.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол олгох сургалт, түүнчлэн энэ хуулийн 4.1.4-т заас үйл ажиллагааг хамтад нь мэргэжлийн боловсрол сургалт гэж ойлгоно.

5 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол сургалтын зорилго

5.1. Мэргэжлийн боловсрол, сургалтыг зорилго нь иргэний авьяас, сонирхол, хөдөлмөр эрхлэх хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндэс зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлаг нийцүүлэн мэргэжлийн ур чадвар, боловсрол эзэмшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх; хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэхэд оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага

6 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл

6.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төр, баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, хувь хэвшилийн тэнцүү оролцоог хангаж, тогтвортой ажиллах баталгааг бүрдүүлсэн орон тооны (байгууллага мөн).

6.2. Энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагыг хэрэгжүүлнэ.

6.3. Зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.3.1. мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх урт, дунд болон богино хугацааны бодлого, хөтөлбөрийг хэлэлцэж дүгнэж гаргах;

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Боловсролын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

³ Бага, дунд боловсролын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

⁴ Дээд боловсролын тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.

⁵ Хөдөлмөрийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 19 дүгээрт нийтлэгдсэн.



6.3.2. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6.3.3. мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл, илтгэл, зөвлөмж гаргах, чиглэл өгөх;

6.3.4. улсын хэмжээнд мөрдөх ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын стандартыг кэлэлцэж дүгнэлт гаргах;

6.3.5. мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

6.3.6. мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой олон улсын гэрээ, конвенцид Монгол Улс нэгдэн орох асуудлыг судалж, санал гаргах;

6.3.7. гаргасан шийдвэр, өвлөмжийнхээ хэрэгжилтэд хяналт тавих.

6.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг энэ хуулийн 1.5-д заасан байгууллагын саналыг үндэслэн тасгийн газар батална.

6.5. Зөвлөлийн бүрэлдэхүүн дэх хувийн эвшлийн төлөөллийг ажил олгогчид болон судалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран зохион агуулсан төрийн бус байгууллага, мэргэжлийн олбоодын нэгдсэн хурлаас сонгоно.

6.6. Зөвлөлийн дүрмийг Засгийн газар атална.

6.7. Зөвлөл ажлаа Засгийн газарт айлгана.

7 дугаар зүйл. Төрийн захиргааны төв айгууллагын бүрэн эрх

7.1. Боловсролын болон хөдөлмөрийн суудал эрхэлсэн, түүнчлэн бусад төрийн захиргааны төв байгууллага хуулиар тогтоосон эхлэх асуудлын чиглэлээр энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийг бодлогоор дэмжиж, мэргэжил, эрга зүйн удирдлагаар хангана.

8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, түүний бүрэн эрх

8.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын шаархт төрийн бодлого, Засгийн газрын болон энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн шийдвэрийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байна.

8.2. Энэ хуулийн 8.1-д заасан төрийн захиргааны байгууллагын даргыг нь Засгийн газрын тухай хуулийн⁷ 18³ дугаар зүйлд заасны дагуу томилж, чөлөөлнө.

8.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

8.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.4.1. мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр батлагдсан ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8.4.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

8.4.3. мэргэжлийн болон техникийн боловсролын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн төлөвлөх;

8.4.4. төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах талаар дүгнэлт гаргах;

8.4.5. хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, сурталчлах, энэ чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

8.4.6. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын хүний нөөц, суралцагчдын нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтэд зохицуулалт хийх;

8.4.7. сургалт-үйлдвэрлэл, үйлдвэрлэл-сургалтын явцад шинэ технологи, шинжлэх ухаан, техникийн ололт, дэвшилийг нэвтрүүлэх арга хэмжээ авах;

8.4.8. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, дүн шинжилгээ хийх, ангиллыг тогтоох;

8.4.9. мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах;

8.4.10. мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, чадалын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах;

7-сгийн газрын тухай хууль - Төрийн мэдээлэл эмхтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

8.4.11. мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах;

8.4.12. мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи статистик болон бусад мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сан бүрдүүлэх, хөтлөх;

8.4.13. төрийн өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

8.4.14. төрийн өмчийн болон төрийн өмчийн бус мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах;

8.4.15. мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар шаардлагатай мэдээ тайлан, тооцоо судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

8.4.16. мэргэжлийн болон техникийн боловсролын асуудлаар олон улсын гэрээ, конвенци, хэлэлцээрээр Монгол Улсын Засгийн газрын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, зохицуулах;

8.4.17. мэргэжлийн болон техникийн боловсролын чиглэлээр хийгдэх төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар хариуцуулан гүйцэтгүүлэх талаар судлах, санал боловсруулах;

8.4.18. энэ хуулийн 8.4.17-д заасан чиглэлээр хийгдсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

8.4.19. мэргэжлийн сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах;

8.4.20. мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоодын оролцоотойгоор ажил, мэргэжил, ур чадварын стандарт боловсруулах, модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, стандарт

9 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга

9.1. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид ажил мэргэжлийн үндэсний ангиллаар тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ.

9.2. Техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид технологийн процессийг удирдах, мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэх бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэж, улмаар хэсэг тус бүрийн агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

9.2.1. ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжил, боловсрол, эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухаан, техникийн суурь мэдлэг олгох;

9.2.2. мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид үйлдвэрлэл, үйлчилгээ, техник технологийн чиглэлээр шинэ техник эзэмших өөрчлөлтөд зохицож хөгжих, тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар олгох;

9.2.3. мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжлийн үйл ажиллагааны чадвар дадал эзэмшүүлэх, тухайн мэргэжлээр сонгож мэргэшүүлэх.

9.3. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалттай хослуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд бүрэн дунд боловсролын агуулга нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 6 дугаа зүйлд заасан зорилтод нийцсэн байна.

9.4. Мэргэжлийн сургалтын агуулга нь тодорхой түвшний ур чадвар эзэмшүүлэхэд зориулан боловсруулсан модулиас бүрдэнэ.

9.5. Энэ хуулийн 9.2-т заасан боловсрол эзэмшүүлэх сургалтыг багц цагт үндэслэн зохион байгуулна.

10 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол сургалтын стандарт

10.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт нь мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, төлөвшүүлэх сургалтын агуулгыг түүний үнэлгээ, багшийн мэргэжил, сургалтыг орчинд тавих үндсэн шаардлагыг тодорхойлно.

10.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын загварыг Стандартчилал, тохирлы үнэлгээний тухай⁶ хуулийн 6.5-д заасны дагуу баталж, улсын бүртгэлд бүртгэнэ.

⁶ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2003 оны 21 дүгээрт нийтлэгдсэн.



11 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалт

11.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь танхимын хичээл, үйлдвэрлэлийн сургалт, дадлагын ажил байна.

11.2. Үйлдвэрлэлийн сургалт, дадлагын ажлыг сургууль дээрх, ажлын байран дахь, төгсөлтийн өмнөх гэсэн үе шаттайгаар зохион байгуулна.

11.3. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалт нь өдрийн, оройн, зайны, үйлдвэр дээрх гэсэн хэв шинжтэй байж болно.

11.4. Үйлдвэрлэлийн дадлагын ажил хийлгэх асуудлаар аж ахуйн нэгж, байгууллага, суралцагч, сургууль гурван талт гэрээ байгуулна.

12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага

12.1. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, үр чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.

12.2. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь илг үүргээсээ хамваран мэргэжлийн боловсролын, гехникийн боловсролын болон мэргэжлийн сургалтын гэсэн ангилалтай байна.

12.3. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

12.4. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг бие даасан, эсхүл сургалтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулж болно.

12.5. Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж юм.

12.6. Политехник коллеж нь харьяалалдаа мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай байж болно.

12.7. Мэргэжлийн сургалтын байгууллага нь үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, өдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллага зэрэг хэв шинжтэй байж болно.

12.8. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь тусгай зөвшөөрөл авсан байх бөгөөд сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөлийг хангаж, сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулна.

12.9. Мэргэжлийн сургалтыг зохих зөвшөөрөл авсан сургалтын байгууллага, аж ахуйн нэгж зохион байгуулж болно.

12.10. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

12.11. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлага, удирдах зөвлөлийг байгуулах, ажиллуулахтай холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 33, 36 дугаар зүйлээр зохицуулна.

13 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

13.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, номын сан, соёл-спортын болон мэдээллийн төвтэй байна.

13.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага нь бүрэлдэхүүндээ, эсхүл харьяалалдаа мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэх нэгж, бизнес инкубатор, туслах аж ахуйтай байж болно.

13.3. Төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалт-үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгон ажиллуулж болно.

14 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх

14.1. Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг Засгийн газар байгуулна.

14.2. Төрийн өмчийн бус мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу

зохих зөвшөөрөл авсан хуулийн этгээд байгуулж болно.

14.3. Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 20-24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

14.4. Мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх богино хугацааны, эсхүл мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, түүнчлэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасны дагуу зохион байгуулсан сургалтыг зохих журмын дагуу бүртгүүлсэн хуулийн этгээд эрхэлж болно.

14.5. Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

15 дугаар зүйл. Суралцагч элсүүлэх

15.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь иргэнийг эзэмшсэн боловсрол, ур чадварын түвшин, хэрэгцээ, сонирхолд нь үндэслэн зохих модулийн сургалтад элсүүлнэ.

15.2. Техникийн боловсролын сургалтын байгууллагад бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.

15.3. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх мэргэжлийн чиглэл, хяналтын тоо, элсэлтийн үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлж Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан байгууллага батална.

15.4. Мэргэжлийн сургалтад суралцагч элсүүлэхэд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгыг үндэслэнэ.

15.5. Ажил, мэргэжлийн тодорхой чадамжийг эзэмших, ур чадвараа дээшлүүлэх, давтан суралцах хүсэлтэй иргэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад нас, боловсролын түвшин харгалзахгүйгээр хөдөлмөр эрхлэх мэргэжлийн болон аж ахуй эрхлэх сургалтад хамрагдана.

16 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарын үнэлгээ

16.1. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журмыг боловсролын асууда, эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага, суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц өөрчлөлтийг сургалтын явцад болон анги дэвшил сургууль төгсөхөд нь шалган үнэлж, энэ хуулийн 16.3-т заасны дагуу сургалтын стандартыг хэрэгжилтийг дүгнэнэ.

16.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартын хэрэгжилтийг багшийн үнэлгээ, сургалтын байгууллагын шалгалтын боловсролын үнэлгээний байгууллагын дүнгээ тодорхойлно.

16.4. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь төгсөгчид дараахь бичиг барим олгоно:

16.4.1. мэргэжлийн сургалтыг хөтөлбөрийг бүрэн хэмжээгээр хангасан, эсхү үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад ажилла тухайн мэргэжлээр модулийн бүрэн багц эзэмшиж, энэ хуулийн 16.7-д заасан шалгалт өг тэнцсэн иргэнд мэргэжлийн үнэмлэх;

16.4.2. суурь боловсрол эзэмш сэнний дараа 2.5-аас доошгүй жил суралца мэргэжил, бүрэн дунд боловсролыг хамтад н эзэмшсэн иргэнд мэргэжлийн боловсролы үнэмлэх;

16.4.3. техникийн боловсро эзэмшигчид мэргэжлийн диплом.

16.5. Энэ хуулийн 16.4.2-т заасан үнэмл: нь бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг гэрчилнэ

16.6. Мэргэжлийн сургалтын байгууллага н мэргэжлийн тодорхой түвшний ур чадвар олгч модулийг эзэмшсэн суралцагчид чадамжийг гэрчилгээ олгоно.

16.7. Хөдөлмөрийн асуудал эрхэлс: төрийн захиргааны байгууллагатай гэр: байгуулсан төрийн бус байгууллага тодорх: мэргэжлээр ур чадварын шалгалт зохион байгуу: болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

17 дугаар зүйл. Мэргэжлийн болс техникийн боловсролын сургалты байгууллагын суралцагчийн эрх, үүрэг

* Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсн

17.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараахь эхтэй:

17.1.1. сургалтын техник хэрэгсэл, энэ төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ элбэргүй ашиглах;

17.1.2. үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн зөвлөн дагаладантай орон тоон дээр ажилласан боловсролын хөлс авах, хөнгөлөлт эдлэх;

17.1.3. мэргэжлийн сургалтын үйлдвэрлэлийн төвийг дээд үнэлгээтэй төгсөгч нь аталсан сургалттай техникийн боловсролын сургалтын байгууллагын дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцах;

17.1.4. Засгийн газраас тогтоосон зарчмын дагуу Боловсролын тухай хуулийн 43.2-т заасан нийгмийн баталгаагаар хангагдах.

17.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч боловсролын тухай хуулийн 45.2-т зааснаас гадна үйлдвэрлэлийн дадлагын ажлын үед аж ахуйн нэгж, йгууллагын дотоод журам, хөдөлмөр хамгаалал, үүлгүй ажиллагааны дүрэм, энэ хуулийн 11.4-т заасан гэрээний заалтыг сахин биелүүлэх үүрэгтэй.

17.3. Энэ хуулийн 17.1.2-т заасныг зөрчсөн бол тушаалтныг 50000-60000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох үйлтэлийг боловсролын хяналтын улсын байцаагч гдуулна.

18 дугаар зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш

18.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь талаар, түүнээс дээш зэрэгтэй, үйлдвэрлэлийн болон зохиох дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

18.2. Мэргэжлийн сургалтыг хөтлөн ирдах багш нь үйлдвэрлэл, технологийн шиллагаатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, багшлах эрхтэй байна.

18.3. Багшийн мэргэжил эзэмшээгүй орон нутгийн багш нь сургалтын заах арга зүй эзэмшиж, шилжих эрхийн үнэмлэх авсан байна.

18.4. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын онолын болон дадлагын багшийн сургалтын цагийн ачаалал, цалин хөлс, амралтын үйлдвэрлэл нь адил тэгш байна.

18.5. Энэ хуулийн 18.4-т заасан багшийн цалин, нэмэгдэл хөлс олгох журмыг санхүүгийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран, харин ажлын байрны тодорхойлолт, сургалтын цагийн ачааллыг тогтоох, тооцох журам, аргачлал, зөвлөмжийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тус тус батална.

18.6. Энэ хуулийн 18.4-т заасан багшид заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн зэрэг олгоно.

18.7. Багшлах эрх, энэ хуулийн 18.6-д заасан зэрэг олгох, хасах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19 дүгээр зүйл. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн эрх, үүрэг, нийгмийн баталгаа

19.1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 44.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

19.1.1. үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу гэрээгээр ажиллах, мэргэшил дээшлүүлэх, зөвлөгөө өгөх;

19.1.2. шинэ техник, технологи судлах, дадлага хийх;

19.1.3. бүтээлийн чөлөө авах.

19.2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

19.2.1. сургалтын явцад эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах;

19.2.2. аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн туслалцаа үзүүлэх;

19.2.3. шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтандаа эдгээрийг хэрэглэх.

19.3. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, түүнтэй адилтгах мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын багш нь Боловсролын тухай хуулийн 43.1-д заасан баталгаагаар хангагдахаас гадна түүнд 5 жил тутамд нэг удаа 10 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа сургалтын байгууллагаас олгоно.



20 дугаар зүйл. Нийгмийн түншлэл

20.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг сонирхогч этгээд нэгдэн нийгмийн түншлэлийг бүрдүүлнэ.

20.2.Нийгмийн түншлэл нь дараахь чиглэлээр хамтран ажиллана:

20.2.1.мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого боловсруулахад оролцох;

20.2.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах;

20.2.3.мэргэжлийн хяналт шинжилгээний тогтолцоог бүрдүүлэх, сургалтын агуулга, стандарт боловсруулахад оролцох;

20.2.4.үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран зохион байгуулах;

20.2.5.багш нарын мэргэшил дээшлүүлэх;

20.2.6.мэргэжлийн шалгалт хамтран авах;

20.2.7.төгсөгчийг ажлын байраар хангах;

20.2.8.багш, инженер-техникийн ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

20.2.9.үйлдвэрлэлийн техник, технологийг шинэчлэх, судалгаа, туршилт хамтран явуулах;

20.2.10.хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

20.3. Салбар, Үйлдвэрийн онцлогоос хамааран аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд цалингийн сангаасаа энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөлөөс тогтоосон тодорхой хувь хэмжээгээр санхүүгийн дэмжлэг үзүүлж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

21 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилт

21.1.Мэргэжлийн боловсрол, сургалтад зарцуулах хөрөнгийг Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангаас санхүүжүүлэх бөгөөд уг сангийн санхүүгийн удирдлагыг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

21.2.Мэргэжлийн боловсрол, сургалт дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулж түүнд хяналт тавих журмыг Засгийн газар баталнэ.

22 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

22.1.Мэргэжлийн боловсрол, сургалт дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ.

22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.2.орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

22.1.3.гадаад улс, олон улсын байгууллагаас мэргэжлийн боловсрол, сургалт дэмжих зорилгоор олгосон зээлийн хөрөнгийг буцалтгүй тусламж;

22.1.4.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улс, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн байгууллага, иргэдээс өгсөн хандив, тусламж;

22.1.5. аж ахуйн нэгж байгууллагаас энэ хуулийн 20.3-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө;

22.1.6.бусад эх үүсвэр.

23 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн зарцуулалт

23.1.Мэргэжлийн боловсрол, сургалт дэмжих сангийн хөрөнгийг дараахь байдлаар хуваарилан зарцуулна:

23.1.1.төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуу байрны нийт зардал;

23.1.2.өмчийн хэлбэр харгалзж гүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардал олгосон санхүүжилт, тэтгэлэг;

23.1.3.мэргэжил олгох, давтгалт сургалт зохион байгуулах зардал;

23.1.4.хувиараа аж ахуй эрхлэх иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулж зардал;

23.1.5. үйлдвэрлэл дэмжих мэргэжлийн сургалт зохион байгуулах зардал.

24 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв

24.1. Улсын төсвөөс тухайн жилд бэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд гдох хөрөнгийн хэмжээг Улсын Их Хурал тухайн илийн төсөвт тусгаж батална.

24.2. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.

24.3. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын өвийг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал хэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл батална.

25 дугаар зүйл. Сангийн тайлан гаргах

25.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих нгийн орлого, зарлагын тайланг дор дурдсан гацаанд гаргаж, энэ хуулийн 6.1-д заасан Зөвлөл лон хөдөлмөр, санхүү, боловсролын асуудал хэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус ирүүлнэ:

25.1.1. улирлын нэгдсэн тайланг дараа орлын хоёр дахь сарын 5-ны дотор:

25.1.2. жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор.

26 дугаар зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

26.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

27 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

28 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

28.1. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буюу 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

09 оны 02 дугаар
рын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуульд дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт эсүгэй:

1/ 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"14.2. Бүрэн дунд боловсрол олгох галтыг мэргэжлийн боловсролын сургалтын тууллага эрхэлж болно."

2/ 14 дүгээр зүйл:

"14 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, галтын байгууллага

14.1. Мэргэжлийн боловсрол, сургалтын тууллага нь политехник коллеж, мэргэжлийн галт-үйлдвэрлэлийн төв зэрэг хэв шинжтэй байж ино.

14.2. Политехник коллеж нь техникийн оловсролын сургалт эрхэлдэг байгууллага байна."

3/ 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт:

"28.1.21. Бүж шатны боловсролын галтын байгууллагыг аттестатчилах журмыг алж мөрдүүлэх;"

4/ 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 14 дэх заалт:

"30.1.14. орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлөх;"

2 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн "бага, дунд" гэсний дараа "мэргэжлийн боловсрол," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсгийг "Боловсрол, сургалтын стандартыг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллага дагаж мөрдөнө." гэж өөрчлөн найруулсугай.

4 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.12, 28.1.19 дэх заалт, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн "мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв" гэснийг "мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага" гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсэг, 43 дугаар зүйлийн 43.2.2 дахь заалтын "мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн" гэснийг "мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын" гэж, 28 дугаар зүйлийн 28.1.8 дахь

заалтын "коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг" гэснийг "коллежийг" гэж, 40 дүгээр зүйлийн 40.6 дахь хэсэг, мөн зүйлийн 40.4.3 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.2.10 дахь заалтын "мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд" гэснийг "мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад" гэж, 28 дугаар зүйлийн 28.1.21 дэх заалтын дугаарыг "28.1.22" гэж, 30 дугаар зүйлийн 30.1.14 дэх заалтын дугаарыг "30.1.15" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Боловсролын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. дэх хэсгийн "мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв" гэснийг, 36 дугаар

зүйлийн 36.1 дэх хэсгийн "Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн төлөөллийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна." гэсэн 2 да өгүүлбэрийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрө эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 02 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаат
хот

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 15.7.5, 15.7.6 дахь заалт нэмсүгэй:

"15.7.5.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага байгуулах;

15.7.6.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад шинэ мэргэжлээр сургалт явуулах."

2 дугаар зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар

зүйлийн 15.7.1 дэх заалтыг "их сургууль, дэ сургууль, коллеж байгуулах." гэж өөрчлө найруулсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрө эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 02 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаат
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 12.1.28-12.1.31 дэх заалт нэмсүгэй:

"12.1.28.мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын орчныг бүрдүүлэх, дадлагын газрыг тоног төхөөрөмжөөр хангах, дадлагын байрыг засварласан зардал;

12.1.29. багш нарыг дадлагажуулсан зардал;

12.1.30.өөрийн захиалгаар мэргэжилтэн бэлтгүүлэх зорилгоор мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад үзүүлсэн санхүүгийн дэмжлэг;

12.1.31.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд оруулсан хандив, хөрөнө

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.18 дахь заалтыг "мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралгчдын үйлдвэрлэл дээрх дадлага хийлгэхтэй холбогдон гарсан зардал." гэж өөрчлөн найруулсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрө эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 4.24, 6.2.6 дахь заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 24 дэх заалт:

"5.4.24. Мэргэжлийн боловсрол, ургалтыг дэмжих сан."

2/ 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6 дахь заалт:

"6.2.6. Мэргэжлийн боловсрол, ургалтыг дэмжих сан."

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "авто замын" гэсний дараа "сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 5 дугаар сарын 03-ы өдөр батлагдсан Мэргэжлийн боловсрол, ургалтын тухай хуулийг хүчингүй болсонд юуцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Мэргэжлийн

боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

009 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 12.1.32 дахь заалт, 12.9 дэх сэг тус тус нэмсүгэй:

1/12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 32 дахь заалт:

"12.1.32. хувьцаа худалдаж авсан э, эсхүл тухайн хувьцаанд ногдох эзэмшигчийн ичин хэсэг."

2/ 12 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:

"12.9. Ашигт малтмалын илгэлтын тусгай зөвшөөрөл эзэмших болон илжүүлэн авахтай холбогдон гарсан зардлыг хайн тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх гацаанд жил тутам ижил хэмжээгээр

үйлдвэрлэлийн зардалд оруулан шимтгэлийн сан байгуулна."

2 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.22 дахь заалтын "эд зүйл худалдан авсан" гэснийг "зүйлийн" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийн "сүүлд" гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсан өдрөөс нь буруу 2009 оны 2 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

 МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын "төрийн одон медаль," гэсний дараа "мөнгөн тэмдэгт," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6.12 дахь заалтыг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

1/13 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 12 дахь заалт:

"13.6.12 төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээ; Үүнд Засгийн газар, түүний агентлагууд, төсөвт байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээ хамаарна."

3 дугаар зүйл. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 д: заалтын "ногдуулах" гэснийг "ногдуулсан" гэж, дугаар зүйлийн 7.3.5 дахь заалтын "хувь хүн гэснийг "этгээд" гэж, мөн зүйлийн 7.4.9 дэх заалтыг "хувь хүнээс" гэснийг "этгээдээс" гэж, 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын "гадаад улсад" гэснийг "Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна" гэж, 1 дугаар зүйлийн 13.1.9 дэх заалтын "газрын тос хай олборлох, ашиглах" гэснийг "газрын төстс холбоотой" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг батлагдсн өдрөөс нь буюу 2009 оны 2 дугаар сарын 20-н өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 03 дугаар сарын 03-ны өдөр

Улаанбаатар хот

НООТ БИЧИГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэдийн зорчих нөхцөлийг харилцан хөнгөөчлөх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэрэг, худалдааны яам хооронд солилцсон

Ноот бичгийг Засгийн газрын өргөн мэдүүлсэн; соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай /шинэчилсэн найруулга/ хуулиар мэргэжлийн сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааны

одоогийн тогтолцоог хэвээр үлдээх нь зүйтэй г: үзсэн тул Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакция.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар- 12
Төрийн ордон-126 тоот

☎ 262420
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 1.5